



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

*Тэгш,
Чанартай,
Найдвартай,
Хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд*

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ШИНЭЧИЛЖ ТОГТООСОН ТУХАЙ

*Илтгэгч:
ТЗА-ны мэргэжилтэн Е.Нямсүрэн
И-мэйл: nyamsuren@wsrc.mn*

2017.05.12

АГУУЛГА:

- Хууль, эрх зүйн үндэслэл
- Бүтэц, түүний агуулга
- Өөрчлөлт оруулах болсон шалтгаан
- Оруулж буй өөрчлөлтүүд
- Дүгнэлт

НӨХЦӨЛ, ШААРДЛАГА ТОГТООХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- ▶ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн боловсруулсан.



БҮТЭЦ, ТҮҮНИЙ АГУУЛГА

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

Үндсэн 5 бүлэгтэй. Үүнд:

- Нэг. Нийтлэг үндэслэл
- Хоёр. Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад тавигдах шаардлага
- Гурав. Бүрдүүлэх баримт бичиг
- Дөрөв. Тусгай зөвшөөрөл, түүний хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох
- Дөрөв. Бусад зүйл

Үндсэн 3 бүлэгтэй. Үүнд:

- Нэг. Нийтлэг үндэслэл
- Хоёр. Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад тавигдах шаардлага
- Гурав. Тусгай зөвшөөрөл, түүний хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛСОН ШАЛТГААН



- ❑ Өмнөх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын ангилал тус бүрд давхардсан заалтууд орсон, /хүний нөөц, бичиг баримтын бүрдэл гэх мэт/ ерөнхий агуулгатай байгааг энгийн ойлгомжтой болгох,
- ❑ УХАТ-ын шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн ажлыг эрчимжүүлэх хөрөнгийг бий болгох зорилгоор үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцуулж, үнэ тарифын хэрэгжилтийг хангуулах,
- ❑ Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулахгүй, хууль зөрчин үйл ажиллагаа явуулж байгааг таслан зогсоох механизм бүрдүүлэх
- ❑ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд ойртуулах.



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”:

- **Хоёр. Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах нөхцөл, шаардлага**

ААНБ, хэрэглэгч ямар тохиолдолд УХАТ-н ТЗ авах боломжтой талаар суурь ойлголт авах мэдээллийн суурь шалгуур үзүүлэлт болох тул шинээр дараах заалтыг оруулсан.

Үүнд:



2.1 Үйл ажиллагааны чиглэл бүрээр шаардлагатай мэргэжлийн **үндсэн** ажилчдаар хангагдсан байх.

2.2 Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах аж ахуйн нэгж нь санхүүгийн хувьд чадамжтай байх, Тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргагч нь өмнөх онд алдагдалгүй ажилласан байх, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах **“Орон сууцны барилгын үйлчилгээ”** стандартад заасан хөрөнгөтэй байх.



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

“Орон сууцны барилгын үйлчилгээ” стандартад заасан хөрөнгө:

MNS 5681 : 2006

А.Хавсралт (норматив)

А.1. Диспетчерийн албаны бүрэлдэхүүн

Мэргэжлийн нэр	Бүрэлдэхүүний тоо /доошгүй/
Ээлжийн ахлах ажилтан	1 **
Ээлжийн ажилтан	3
Сантехникийн засварчин /цэвэр усны /	3
Ариутгах татуургын засварчин	3 *
Цахилгаанчин	3
Лифтийн механик ба эргэгч	3 **

* -Томоохон хотуудад заавал байх шаардлагатай.

** -Заавал байх шаардлагагүй

А.2. Диспетчерийн албанд байх ёстой баримт бичгийн бүрдүүлэлт ба эд зүйлс

Д/Д	Баримт бичгийн нэр
1	Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээнд дагаж мөрдөх хууль эрх зүйн акт
2	Норм, стандартууд
3	Ажил үйлчилгээтэй холбоотой тушаал, шийдвэрүүд
4	Үйлчилгээний объектуудын байршлын схем
5	Инженерийн шугам сүлжээний схем,
6	Инженерийн хангамжийн судалгаа
7	Түргэн цугларах схем
8	Ажиллагсдын хаягийн бүртгэл, утасны жагсаалт
9	Чухал шаардлагатай буюу үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага аж ахуйн нэгжийн хаяг, утасны жагсаалт, удирдах ажилтны албаны болон гэрийн утасны дугаар
10	Мэргэжлийн байгууллагуудтай холбоотой мэдээ, мэдээллийн дэвтэр
11	Хэрэглэгчдээс эрэлт хүсэлт хүлээн авах дэвтэр
12	Ажлын болон зоорины давхар, адрын өрөөний түлхүүр

А.3. Диспетчерийн албаны ажиллагсдад байх багаж хэрэгслэл

Мэргэжлийн ангилал	Багаж хэрэгслэлийн нэр	Тоо ширхэг
Ээлжийн ажилтан	Материал сэлбэгийн нөөц	1 багц
	Багаж хэрэгслэлийн нөөц	1 багц
	Далд монтажийн гэмтэл илрүүлэгч	1 багц
Сантехникийн болон ариутгах татуургын засварчин	Газов -0, 1, 2, 3	4
	Отвертка /төрөл бүр/	1 багц
	Бахь	1
	Төмрийн хөрөө, рам, нөөц иртэй	1
	Хайч	1
	Төрөл бүрийн түлхүүр	1 багц
	Урт, богино тросс	1
	Бөглөө гаргагч	1

А3 хүснэгтийн үргэлжлэл

Цахилгаанчин	Индикатор	1
	Бахь	1
	Отвертка /төрөл бүр/	1 багц
	Утас үзүүрлэгч бахь	1
	Төрөл бүрийн түлхүүр /төрөл бүр/	1
	Гар чийдэн	1
	Нөөц цахилгааны утас/1-3 м/	1
Лифтийн механик ба эргэгч	Төрөл бүрийн түлхүүр	1 багц
	Бахь	1
	Отвертка /төрөл бүр/	1
	Алх	1
	Төмрийн хөрөө, рам	1
	Соёмник	1
	2 шүдтэй тусгай түлхүүр	1
	Индикатор	1
	Цахилгааны хэмжигч багаж	1 багц
	Хаалга онгойлгогч	2

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД



2.4 Тусгай зөвшөөрөл сунгуулах Тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид ТЗЭ гэх/ нь байгууллагынхаа орлого болоогүй усны хэмжээг зөв тооцоолж, усны алдагдлыг бууруулсан байх.



2.6.1 в-2.6.2 в.Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

2.6.2 д.Ус цэвэршүүлэх технологийн ажиллагааны горим, техник технологи нь шаардлага хангасан, лабораторийн шинжилгээний дүн, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй, усны чанарын стандартын шаардлага хангасан байх;



2.6.4 Орон сууцны доторхи цэвэр бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын /сантехникийн/, дулаан хангамжийн мэргэжлийн инженер, ээлжийн диспетчер...

д.Сарын усны хэрэглээ 8000м³-ээс доошгүй байх;

шинэчилсэн

д.Сард борлуулж буй усны хэмжээ нь үйл ажиллагааг хэвийн, алдагдалгүй явуулах нөхцлийг хангасан байх;

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Гурав. Тусгай зөвшөөрөл, түүний хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

4.2 Тусгай зөвшөөрөл сунгуулах ТЗЭ нь үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ийг жил бүр дүгнэж, ирүүлсэн байна.

ААҮАТЗТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.” гэж заасан байдаг тул шинээр дараах заалтыг оруулсан.

Үүнд:

4.3 Тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу 3 /гурав/ жилийн хугацаагаар олгох бөгөөд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үр дүнг үндэслэн 5 /тав/ хүртэл жилийн хугацаагаар сунгана.

Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулахгүй, хууль зөрчин үйл ажиллагаа явуулж байгааг таслан зогсоох механизмыг бүрдүүлж дараах заалтыг шинээр оруулсан:

4.4 Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө шаардлагад нийцсэн тусгай зөвшөөрлийн материалыг бүрэн бүрдүүлж ирүүлээгүй бол гэрчилгээнд заасан хугацаанаас хойш тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно.




ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ШИНЭЧИЛСЭН ХУУЛИЙН ХҮРЭЭНД БҮРТГҮҮЛСЭН БАЙДАЛ

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-иар олгогдсон эрхийн дагуу тус Зохицуулах Зөвлөлийн 2016 оны 98 тоот тогтоолоор “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ыг шинэчлэн баталлаа.

Захиргааны ерөнхий хууль болон Хууль зүйн сайдын 2016 оны А/222 дугаар тушаалын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан ёсоор бүртгүүлэн, олон нийтэд мэдээлсэн болно

№	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	Эхний өдөр	Төгсөх өдөр	Статус	Хууль
22	A186 ТУСААЙН ХАНГАЛТАД НӨХЦӨЛ ШААРДЛАГА ТУХАЙ 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 98 ТУСААЙН ТУШААЛ	2016-09-23	2020-09-28	✓	2016-10-21-ийн 3492-д 48
23	88 ТУСААЙН ХАНГАЛТАД НӨХЦӨЛ ШААРДЛАГА ТУХАЙ 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 19-Ч ДАГААР БУСААР	2016-09-28	2016-09-28	✓	
24	A81 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-09-27	2020-09-28	✓	
25	A82 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-09-27	2020-09-28	✓	
26	A89 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-09-27	2020-09-28	✓	
27	A84 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-09-27	2020-09-28	✓	
28	222А Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-09-28	2020-09-28	✓	
29	88 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-12-07	2020-09-28	✓	3474
30	A88 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага	2016-10-18	2020-09-28	✓	
31	A17748258 ТУСААЙН ХАНГАЛТАД НӨХЦӨЛ ШААРДЛАГА ТУХАЙ	1999-07-16	1999-07-16	✓	1872



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ШИНЭЧИЛСЭН ХУУЛИЙН ХҮРЭЭНД БҮРТГҮҮЛСЭН БАЙДАЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр.
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mjia.gov.mn,
http://www.mjia.gov.mn

2016 оны 12 сарын 04 № 01/5-77-Т
танай 2016.12.04-ны № 01/5-77-Т

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Э.ПҮРЭВЖАВ ТАНАА

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны "Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай" 98 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 98 дугаарт бүртгэснийг мэдэгдье.

САЙД

С.БЯМБАЦОГТ

Догоолагдсан 08 2016



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2016 оны 12 сарын 07 өдөр Дугаар 98

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн нөхцөл,
шаардлага шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт, тус Зохицуулах зөвлөлийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тус Зохицуулах зөвлөлийн 2016 оны 83 тоот тогтоолын 1, 3, 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тусгай зөвшөөрлийн шинэчилсэн нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүргүүлэх, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Тусгай зөвшөөрлийн алба /Л.Хишигдулам/, Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/, Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ПҮРЭВЖАВ

ГИШҮҮН

Б.ЖИГЖИД

Ч.БАТТОГТОХ

С.ЧУЛУУНХУЯГ

Р.НЯМЖАВ



ДУГНЭЛТ

- ▶ Энэхүү журмыг УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТЗЭ-дэд тавих шалгуур үзүүлэлт болгон хэрэглэх бөгөөд журмаар зохицуулагдаагүй бусад шаардлагыг Зохицуулах зөвлөлөөс батлан гаргасан бусад дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэх болно.
- ▶ “Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан нь ТЗЭ-ийн үйл ажиллагааг хүртээмжтэй, найдвартай хэрэглэгчдэд хүргэх, ТЗЭ-ийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг бэхжүүлэх, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх, салбарын үйл ажиллагаа явуулах орчин нөхцлийг дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой.
- ▶ Цаашдаа Зохицуулах зөвлөлөөс энэхүү нөхцөл, шаардлагыг улам боловсронгуй болгох, усны үйлчилгээг олон улсын жишигт хүргэхэд анхаарах болно.

***АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА***